



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/220/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Гэрэлмаа
Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.06 № 21

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын нормативын хэмжээг шинэчлэн тогтоосон байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Чиглэл батлах тухай" 2022 оны А/500 дугаар тушаалын дагуу багш, байгууллагын гүйцэтгэлийг үнэлсэн үнэлгээгээр 32,452.0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна. Үүнээс байгууллагын менежментийг сайжруулахад 11,358.0 мянган төгрөг, багш ажилчдын урамшуулалд 21,094.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Японы хүүхдийг ивээх сангийн дэмжлэгтэйгээр тус сургуульд хэрэгжүүлж буй "Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь" төслийн хүрээнд 9 багш чадавхжуулах сургалтад хамрагдсан байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 478,878.0 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 240, 241 дүгээр тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

- 07020111

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 117,360.3 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, бусад эх үүсвэрээс 34,369.6 төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд төсвийн захирагчийн 4 зорилтын хүрээнд 69 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 64 арга хэмжээ бүрэн, 5 арга хэмжээг 65.0 хувь буюу нийт дүнгээр 92.7 хувиар биелүүлж биелэлтийг хүргүүлсэн боловч дээд байгууллагаас ажлыг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Т.ГҮНЖИДМАА

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	178,040.2	267,803.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,034,529.7	5,907,353.2
Нийт хөрөнгийн дүн	6,212,569.9	6,175,156.4
Нийт өр төлбөрийн дүн	-	7,084.0
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,212,569.9	6,168,072.4
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,212,569.9	6,175,156.4
Үйл ажиллагааны орлогын дүн	8,380,202.2	2,568,278.2
Үйл ажиллагааны зардлын дүн	2,141,080.0	2,611,255.8
Үйл ажиллагааны үр дүн	0.0	0.0
Үйл ажиллагааны бус үр дүн	0.0	0.0
Үйл ажиллагааны нийт үр дүн	6,239,122.2	(44,497.5)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	(8,232.2)	6,212,569.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	(8,232.2)	6,212,569.9
Тайлант оны үр дүн	6,239,122.2	(44,497.5)
Эцсийн үлдэгдэл	6,212,569.9	6,168,072.4
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,010,029.7	2,538,418.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,992,959.5	2,320,478.6
Үйл ажиллагааны ЦМГ	12,232.2	107,663.9
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(4,838.0)	(110,276.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,009,685.5	2,429,695.9
Урсгал зардал	2,004,847.5	2,429,695.9
Хөрөнгийн зардал		-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,009,685.5	2,062,694.2
Улсын төсвөөс санхүүжих	1,574,481.9	2,047,658.9
Орон нутгийн төсвөөс санхүүжих	424,965.6	475,724.6
	-	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 29,888.9 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн байдлын тайланд 7,084.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй, үр дүнгийн тайланд зардлыг илүү, өмчийн өөрчлөлтийн тайланд тайлант үеийн үр дүнг зөрүүтэй,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Авлагыг 80.0 мянган төгрөгөөр дутуу, цалинг илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.
- **Бусад хууль тогтоомжтой холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд дутуу шивсэн 22,724.9 мянган төгрөгийн гүйлгээг системд нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 13,128.7 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 13,128.7 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрснээс, 220.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 12,908.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 4 албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1 Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 105.3 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөрийг олгохдоо 114.7 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2022 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 133/ШШ2022/00293 дугаар шийдвэр" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж бараа үйлчилгээний бусад зардлаас 660.0 мянган төгрөгийн гүйлгээ, урсгал засварын зардлын төсвөөс 6,460.2 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтын "бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг байгууллага гуравдагч этгээдийн багц үйлчилгээг худалдан авахад

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төлөх зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Тус бүлгийн зардлуудыг эдийн засгийн ангилал тус бүрээр хянаана." Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" Урсгал засварын зардал: Байгууллага өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга, байгууламж, тээврийн хэрэгсэлд урсгал шинжтэй засвар хийх зориулалтаар бэлтгэсэн материал, сэлбэг, засвар, үйлчилгээний ажлын хөлс энд хамаарна." гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Монголын цахилгаан холбоо ХК-тай байгуулсан гэрээний дагуу гэрээнд тусгасан ажлыг хийгээгүй байхад 4,690.0 мянган төгрөгийг төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Монголын цахилгаан холбоо ХК, Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн хооронд байгуулсан ерөнхий гэрээний 4.2-т "Талууд барааг хүлээлцсэн акт үйлдэж баталгаажуулсны дараа гүйцэтгэгч нь төлбөрийн хуваарь, нэхэмжлэх болон энэхүү гэрээний 2.7-д заасан баримт бичгийг захиалагчид хүргүүлнэ. Захиалагч нь тухайн нэхэмжлэхийн дагуу төлбөрийг дараа сарын 25-ны дотор 100% төлнө. 4.3-т "Захиалагч нь энэхүү гэрээний 4.2-д заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш барааны нийт төлбөрийн эргэн төлөлтийн хуваарийг баталгаажуулж, 24 сарын хугацаанд хувааж төлж болно." гэсэн заалттай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний биелэлтийг хангуулан ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

3. Хүүхдийн үдийн цайны хоол, хүнсний материал бэлтгэн нийлүүлэх гэрээнд тусгагдаагүй 1,098.5 мянган төгрөгийн бүтээгдэхүүнийг өөрчлөлт оруулахгүйгээр худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.1-т "Захиалагч урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэний улмаас гэрээнд зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийхээс бусад тохиолдолд тендерийн агуулгатай холбоотой гэрээний нөхцөлүүдийг өөрчлөх", 41.1.2-т "энэ хуулийн 40.4, 40.6-д зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх" гэсэн заалттай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний биелэлтийг хангуулан ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

4. Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөр болох 43,636.5 мянган төгрөгийг төсвөөс төлсөн боловч буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлбөрийг буруутай этгээдээс нэхэмжлэн төсвийг хохиролгүй болгох албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургууль	3	29.9	-	-	3	29.9	3	29.9	-	-	-	-
Дүн	3	29.9	-	-	3	29.9	3	29.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургууль	6	13.1	2	0.2	4	12.9	-	-	-	-	-	-
Дүн	6	13.1	2	0.2	4	12.9	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/								
Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургууль	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
-Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			